



Дархан

Хоршоог хөгжүүлэх сангийн зээлийн
дээд хэмжээ, төсөл сонгон шалгаруулах
тов тогтоох тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.13 дугаар зүйлийн 48.1 дэх заалт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны А/243, 2023 оны А/521 дүгээр тушаалаар батлагдсан Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 2 дугаар зүйлийн 2.10, 2.11 дэх хэсэг, 3 дугаар зүйлийн 3.3.1 дүгээр заалтыг үндэслэн Дархан сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Дархан сумын Хоршоог хөгжүүлэх сангаас 2025 онд нэг төсөлд олгох зээлийн дээд хэмжээг хоршоонд 50.0 хүртэл сая төгрөг байхаар тогтоосугай.

2.Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төслийн сонгон шалгаруулалтыг 2025 оны 01 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэл зохион байгуулахаар товлосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын ИТХ-ын зөвлөлд үүрэг болгосугай.

4.Энэ тогтоол гарсантай холбогдуулан 2023 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 22 дугаар тогтоолыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Б.ЭРДЭНЭЗАЯА